# ОРХОН АЙМГИЙН
# БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
# ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 05 сарын 09 өдөр Дугаар А/44 Баян-Өндөр сум

Насанд хүрэгчдийн аймгийн аварга
шалгаруулах тэмцээнд хөрөнгө
гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2009 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 53/45 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсад олон улс, тив, дэлхийн спортын тэмцээн, наадмыг зохион байгуулах, санхүүжүүлэх журам”-ын 4.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.2025 оны 05 дугаар сард зохион байгуулагдах насанд хүрэгчдийн аймгийн аварга шалгаруулах тэмцээний төсвийг хавсралтаар батлсугай.

2.Хавсралтын дагуу санхүүжилтийн гэрээ байгуулж, хяналт тавьж ажиллахыг спортын хэлтсийн дарга (Э.Лхамсүрэнбаатар)-д, спортын тэмцээн, наадмын бодлогын хэрэгжилт, зохион байгуулалт, тайлагналт хариуцсан мэргэжилтэн (Д.Дашбаатар)-д тус тус үүрэг болгосугай

3.Тэмцээнд зарцуулагдах 2,415,000 (хоёр сая дөрвөн зуун арван таван мянга) төгрөгийг зохих журмын дагуу үндэсний тэмцээн наадмын үйл ажиллагааны зардлаас гаргаж, гэрээний дагуу шилжүүлэг хийхийг ерөнхий нягтлан бодогч, аж ахуйн албаны дарга (Ж.Нямжаргал)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА Д.ДЭЛГЭРБАЯР

(D):/2025/Албан хэрэг/Тушаал-25

6125011 25

[illegible]

612502052

Биеийн тамир, спортын газрын даргын
2025 оны 05 дугаар сарын 09..-ны өдрийн
А/44........дугаар тушаалын хавсралт

## НАСАНД ХҮРЭГЧДИЙН АЙМГИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНИЙ ТӨСӨВ

| № | Спортын төрөл | Зардлын нэр | Хүний тоо | Урамшууллын дүн | Бүгд урамшуулал (төгрөгөөр) |
|---|---|---|---|---|---|
| 1 | Буудлага | 1-р байр | 6 | 40,000 | 240,000 |
| | | 2-р байр | 6 | 30,000 | 180,000 |
| | | 3-р байр | 6 | 20,000 | 120,000 |
| 2 | | Медаль | 18 | 15,000 | 270,000 |
| | Дүн | | | | 810,000 |

| № | Спортын төрөл | Зардлын нэр | Ажиллах өдөр | Тоо | Нэг бүрийн үнэ | Бүгд (төгрөгөөр) |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Үндэсний бөх | Шүүгчийн хөлс | 1 | 8 | 100,000 | 800,000 |
| | Дүн | | | | | 800,000 |
| 1 | Шагайн харваа | Шүүгчийн хөлс | 2 | 2 | 100,000 | 400,000 |
| 2 | | Медаль | | 27ш | 15,000 | 405,000 |
| | Дүн | | | | | 805,000 |

Төсвийн нийт дүн: 2,415,000 төгрөг

----oOo---